

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Хуулийн тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлсэн боловсруулж, олон нийтээс ирүүлсэн санал, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган 7 бүлэг 33 зүйлтэйгээр боловсруулсан.

№	Бүлэг	Зүйл	Танилцуулга
1	Нийтлэг үндэслэл	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</p>	<p>1.Хуулийн төслийн зорилтыг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын хөрөнгө оруулалтын орчны мэдээллийн санд буй 124 оны хөрөнгө оруулалтын хуулийн зорилго, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, хуулийн төсөлд ирүүлсэн саналд үндэслэн хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулагчийн эрх үүргийг тодорхойлж өөрчлөн найруулсан.</p> <p>2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь бүх төрлийн салбарт хамаарах тул хуулийн нэрийг тоочих нь орхигдуулах эрсдэлтэй. Иймд, хууль тогтоомж хэсгийг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуульд нийцүүлсэн бусад хууль тогтоомж гэж тодорхойлсон.</p> <p>3.Хуулийн төслийн үйлчлэх хүрээг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн хамааралгүй зохицуулалтыг хасаж, хуулийн төсөлд тусгасан зохицуулалтуудтай уялдуулсан.</p> <p>4.Хуулийн төслийн нэр томъёонд дараах зарчмын нэмэлт, өөрчлөлтийг бий болгосон. Үүнд: -Гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тавигдах шаардлага болох 100 мянган ам.долларын шаардлагыг хүчингүй болгосон. -“Хөрөнгө оруулалтын дэмжлэг” гэсэн нэр томъёог олон улсын жишигт нийцүүлж, “хөрөнгө оруулалтын урамшуулал” (investment incentive) гэж өөрчилсөн. -Хөрөнгө оруулалтыг дэмжих (investment promote) гэсэн томъёоллыг олон улсад хэрэглэгддэг агуулгын дагуу тодорхойлж хуулийн төсөлд тусгасан. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого нь хөрөнгө оруулалтыг татахын тулд хөрөнгө оруулагчид үйлчлэх, мэдээлэх зэрэг чиг үүргийг тодорхойлсон байна. -шууд бус хөрөнгө оруулалт буюу портфолио хөрөнгө оруулалтыг тодорхойлолтыг тусгасан. -хөрөнгө оруулалтын гомдол гэсэн нэр томъёог томъёолсон.</p>

			<p>-гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох зохицуулалтыг хассан тул нэр томъёог хассан.</p> <p>5. Хөрөнгө оруулалт гэсэн агуулгыг өмнөх хуулийн дагуу тодорхойлсныг хэвээр үлдээсэн. Харин хөрөнгө оруулалт хийх хэлбэрийн хүрээг илүү өргөжүүлсэн. Энэ хүрээнд техник хэрэгсэл, үйл ажиллагаагаар хөрөнгө оруулах боломжийг тодорхойлсон. Мөн хөрөнгө оруулалтад хамаарахгүй хэлбэрүүдийг нарийвчлан тусгасан.</p>
2	Хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг	<p>6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын нийтлэг баталгаа</p> <p>7 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх</p> <p>8 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн үүрэг</p>	<p>6.Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэрийн талаар урьдчилан мэдээлэх, хэлэлцүүлэх, саналаа илэрхийлэх боломж олгох, албан ёсоор хэвлэн нийтэлж нээлттэй байлгах баталгааг тусгасан.</p> <p>Хөрөнгийг зөвхөн гагцхүү нийтлэг ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу, нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. Хөрөнгийг дайчлан авах бол бүрэн хэмжээгээр тооцож, зохих ёсоор шуурхай олгох бөгөөд энэхүү нөхөх олговорт ирээдүйд олон ашиг, орлогыг тооцохгүй гэсэн олон улсын зарчмыг тусгасан.</p> <p>Үнэлгээний шалгуур тогтоох журмыг мөн хуулийн төсөлд тусгасан бөгөөд үүнд: хөрөнгийн өнөөгийн үнэ цэн, хөрөнгийн татвар төлсөн үнэлгээг оролцуулсан хөрөнгийн үнэлгээ болон зохистой гэж үзвэл бодит зах зээлийн үнэлгээг тооцож, үнийн хамт төлөхөөр тусгасан.</p> <p>7.Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалт хийх эрх нээлттэй гэж тодорхойлсон. Хөрөнгө оруулалт хийх хязгаарласан салбарыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд энэ хүү мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулагч, олон нийтэд шийдвэр гаргах тухай бүр байнга мэдээлж байхыг төсөлд тусгасан.</p> <p>8.Хөрөнгө оруулагчийн үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг заасан бөгөөд хөрөнгө оруулалтыг бодитой гүйцэтгэх ёстой ба бодитой хийсэн хөрөнгө оруулалт гэснийг хуулийн төсөлд тодорхойлсон.</p>
3	Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын чиг үүрэг	<p>9 дүгээр зүйл.Засгийн газрын чиг үүрэг</p> <p>10 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг</p> <p>11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг</p> <p>12 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллагын чиг үүрэг</p>	<p>9.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй. Хөрөнгө оруулалтын гомдлыг хүлээн авч, эцэслэн шийдвэрлэх, төрийн байгууллагуудад чиглэл өгөх чиг үүргийг шинээр бий болгосон.</p> <p>10.Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яам дангаараа хэрэгжүүлэхээр заасан.</p>

		<p>13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг</p> <p>14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтыг дэмжих талаар Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх</p>	<p>Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ олгох чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд эрх бүхий бусад төрийн байгууллагатай хамтран хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг тусгасан.</p> <p>11.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулагчид мэдээлэл, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр нэгдсэн статистик мэдээллийг гаргах, мэдээллийн санг хөтлөх чиг үүрэгтэй ажиллахаар тусгасан.</p> <p>12.Төрийн бусад байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт, шалгалтыг жилд 2-оос илүүгүй хийх, хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг хууль бус үндэслэлээр зогсоох, түдгэлзүүлэх, саад учруулахыг хориглоно. Энэ тохиолдолд хууль бусад хөрөнгө дайчлан авсанд тооцох талаар тусгасан. Мөн хүчин төгөлдөр шүүх, арбитрын шийдвэрээр төрөөс хохирлыг нөхөн төлөх шийдвэр гарсан бол учруулсан хохирлыг буруутай этгээдээр гаргуулах үндэслэл болно.</p> <p>13.Орон нутгийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллага нь мөн төрийн бусад байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж, хуульд заасан хариуцлагыг хүлээнэ. Ингэснээр хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулж буй төрийн хүнд суртал, нэмэлт шаардлагыг бууруулах ач холбогдолтой.</p> <p>14.Дипломат төлөөлөгчийн газар нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, хөтөлбөрийг сурталчлах, холбох, дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллахаар тусгасан. Энэ харилцааг зохицуулах журмыг гадаад харилцааны болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан.</p>
4	Хөрөнгө оруулалтын урамшуулал	<p>15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын урамшуулал</p> <p>16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын бус урамшуулал</p> <p>17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшуулал</p> <p>18 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох нөхцөл, тавигдах шаардлага</p>	<p>15.Хөрөнгө оруулалтын хуулиар татварын бус урамшуулал болон татварын хувь хэмжээ тогтворжуулах урамшууллыг үзүүлэх боломжтой.</p> <p>16.Татварын бус урамшуулал нь хөрөнгө оруулагч үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дэмжлэг болно. Үүнд, газрын асуудал, ажиллах хүчний зөвшөөрөл, улсын бүртгэлийн асуудал, оршин суух зөвшөөрөл зэрэг үйл ажиллагаа явуулахад үзүүлэх урамшууллыг хамруулсан. Одоо байгаа хуулийн хүрээнд 60 хүртэл жилээр газар ашиглуулах талаар заасан бол үүнийг</p>

		<p>19 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээ авах тухай хүсэлт гаргах</p> <p>20 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох</p> <p>21 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох</p> <p>22 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ</p> <p>23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах</p> <p>24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах</p> <p>25 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>Газрын тухай хуульд заасан газар эзэмших эрхтэй холбоотойгоор 15-60 жил гэж хамгийн бага хугацааг тодорхой болгосон. Мөн газрын асуудлыг заавал Засгийн газар бус Газрын тухай хуульд заасны дагуу холбогдох орон нутаг өөрөө шийдэх эрхийг олгосон.</p> <p>17.Татвар тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын хувь хэмжээ тогтворжуулах урамшууллыг олгохоор заасан. Энэ хүрээнд 4 төрлийн татварыг тогтворжуулах одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн. Мөн татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулах тухай Татварын ерөнхий хуулийн зарчмаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хэрэгждэггүй хуулийн зохицуулалтыг хүчингүй болгосон. Татварын дэмжлэгийг “урамшуулал” гэж нэрлэн, урамшуулал үзүүлэх хугацаа нь гэрчилгээ олгогдсон өдрөөс эхлэн гэрчилгээний хүчинтэй хугацаанд үзүүлнэ гэж төсөлд тусгасан.</p> <p>18. Тогтворжуулах гэрчилгээ авах журмыг хялбаршуулсан. Тогтворжуулах гэрчилгээг 5-аас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид олгох бөгөөд нутаг дэвсгэрийг Улаанбаатар хот болон бусад гэж ангилсан. Тогтворжуулах гэрчилгээний хугацааг доод тал нь 10 жил байх бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээг Улаанбаатар хотод 20-50 тэрбум, орон нутагт 10-50 тэрбум төгрөг байхаар төсөлд тусгасан. 15 жил тогтворжуулах төслийн хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ 50 тэрбумаас дээш 100 тэрбум, 20 жил тогтворжуулах төслийн хувьд 100 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр тусгасан.</p> <p>19.Тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, хүсэлтэд хуулийн этгээдийн баталгаа, танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ, бизнес төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хавсаргахаар тусгасан.</p> <p>20.Тогтворжуулах гэрчилгээг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.</p> <p>21. Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох үндэслэлийг тодорхойлсон. Үүнд хуульд заасан өмнөх нөхцөлүүдийг хэвээр үлдээв.</p> <p>22-25. 500 тэрбум төгрөг ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх этгээд нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтээ илэрхийлсний үндсэн дээр асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, эрх авсны үндсэн дээр уг гэрээг салбарын сайд, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн сайд хамтран байгуулахаар тусгасан. Уг гэрээний хугацаа</p>
--	--	--	--

			нь төслийн хугацаанаас хамаарах бөгөөд энэ нь 20 жилээс багагүй байхаар төсөлд тусгасан.
5	Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа	26 дугаар зүйл.Хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг хүлээн авах 27 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл, түүний ажиллах журам 28 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан магадлах 29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэх	Хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирол, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд гомдол гаргах эрхийг бий болгосон. Уг зөвлөл нь хууль ёсны эрх ашгийг хамгаалах асуудлаар шийдвэр гаргах бус зөвлөн туслах, асуудлыг зуучлан шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Уг зөвлөл нь учирсан нөхцөлийг байдлыг тодруулсны үндсэн дээр шийдвэрлэх саналыг боловсруулан Засгийн газарт танилцуулж, төрийн захиргааны эцсийн шийдвэрийг гаргах боломж бүрдэнэ.
6	Хөрөнгө оруулалтын маргаан	30 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын маргаан	1.Хөрөнгө оруулагч - төр хооронд үүсэх хөрөнгө оруулалтын маргаан. Арбитрын хэлэлцээрийг талууд харилцан тохиролцож бичгээр үйлдсэн байхыг холбогдох Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод заасан байдаг. Монгол Улс нь ICSID Convention буюу Улс болон гадаад улсын иргэн хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцод нэгдэн орсон. Уг Конвенцод арбитрын хэлэлцээрийг бичгээр үйлдсэн байхыг мөн шаарддаг. Хөрөнгө оруулагч, төр хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргаан нь дараах 3 арбитрын хэлэлцээрт үндэслэж арбитрт хандах эрх үүсдэг: (i) хөрөнгө оруулалтын гэрээ (ii) хоёр талт олон улсын гэрээ (iii) хөрөнгө оруулалтын хуульд төр нь хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитраар шийдвэрлэх нэг талын зөвшөөрөл (arbitration consent)-ийг өгөх. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч нь арбитрт нэхэмжлэл гаргаснаар нэг талын зөвшөөрлийг хүлээн авсанд тооцох бөгөөд арбитрын хэлэлцээр бичгээр үйлдэгдсэнд тооцох үндэслэл болно. Хуулийн төсөлд (iii)-т дурдсан төрийн зөвшөөрлийг олгож байгаа нь онцлог зохицуулалт болсон. Энэ зарчим олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бөгөөд ийм зохицуулалтыг тусгасан олон улс орон үндэсний хууль тогтоомждоо тусгасан байдаг. 2.Шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан маргаан. Татвар, газар зэрэг шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлэхийг төслийн 32.3-т заасан. 3.Иргэн, хуулийн этгээд хоорондын арилжааны маргаан. Арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцоо зарчмын дагуу байгуулагддаг буюу маргаанаа шийдвэрлүүлэх арбитраа

			талууд хэлэцээрийн хүрээнд тохиролцдог. Арбитрын хэлэлцээртэй бол талууд арилжааны маргаанаа арбитрын дагуу шийдвэрлүүлэх, ийм тохиролцоогүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх ерөнхий заалт оруулсан.
7	Бусад зүйл	31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт 33 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох	Хууль хүчин төгөлдөр болсноор өмнөх хуулийн дагуу гэрчилгээ авсан, гэрээ байгуулсан байгуулсан этгээдийн эрх ашгийг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгасан. Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх болон хууль хүчин төгөлдөр болох заалтыг тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

COMPREHENSIVE INTRODUCTION TO THE DRAFT LAW

The draft law has been developed in compliance with the concept of the revised draft Law on Investment and the requirements of the Law on Legislation. It incorporates feedback from the public and input from members of the Government; and consists of seven chapters and 33 articles.

№	Chapter	Article	Introduction
1	General Provisions	Article 1. Purpose of the Law Article 2. Investment Legislation Article 3. Scope of the Law Article 4. Definitions of Terms in the Law Article 5. Forms of Investment and Investment Activities	<ol style="list-style-type: none"> 1. The purpose of the draft law has been revised; based on the 124 investment laws in the United Nations Conference on Trade and Development's (UNCTAD) investment environment database, recommendations from international organizations, and feedback on the draft law. The purpose is to promote investment, protect the rights and legitimate interests of investors, and define the role of assisting investors. 2. Since investment activities encompass all sectors, listing specific sectors in the law title poses a risk of omission. Therefore, the legislation section is defined as: the Constitution of Mongolia, this law, and other laws aligned with these. 3. The scope of the draft law has been adjusted in accordance with the requirements set out in the Law on Legislation, removing irrelevant provisions and aligning it with regulations included in the draft law. 4. The draft law introduces the following fundamental additions and amendments to the terminology, namely: the amendments include: <ul style="list-style-type: none"> • The requirement of a minimum capital investment of USD 100,000 - for foreign investors in legal entities - has been abolished. • The term "investment support" has been aligned with international standards and revised to "investment incentive." • The concept of "investment promotion" has been clarified in accordance with international practice. The draft law defines policies to attract investors, including provisions for services, information, and other functions to assist investors. • The draft includes a definition for "indirect investment", also known as portfolio investment. • The term "investment complaint" has been formalized. • The regulation requiring permits for foreign state-owned entities has been removed, along with the related terminology. The definition of "investment" from the previous law has been retained, while expanding the scope of "investment forms". This now includes the possibility of investment through technology, equipment, and operations. • Specific forms that do not qualify as investments have been outlined in detail.

			<p>5. The concept of "investment" has been kept as outlined in the previous law. However, the scope of "investment forms" has been broadened to include possibilities for investment through technology, equipment, and operations. Forms that do not qualify as investments have also been specified in detail.</p>
2	Investment Guarantees, Rights, and Obligations of Investors	<p>Article 6. General Investment Guarantees Article 7. Rights of Investors Article 8. Obligations of Investors</p>	<p>6. Guarantees have been included to ensure that investors are informed in advance of any decisions affecting their rights and legitimate interests, with opportunities for consultation, expression of opinions, and official publication for transparency. Property may be expropriated only for public interest, following a non-discriminatory principle, strictly in accordance with legal grounds and procedures, and with conditions for compensation. If property is expropriated, full compensation must be provided promptly, based on current value, without including expected future profits, in line with international principles.</p> <p>The draft law also includes procedures for establishing valuation criteria, which consider the current value of the property, its assessed value with taxes paid, and, where deemed appropriate, the fair market value. Compensation is to be calculated based on these valuations and paid accordingly.</p> <p>7. An investor is defined as having the unrestricted right to make investments. Sectors restricted for investment shall only be established by law, and this draft stipulates that the government authority responsible for investment matters must continuously inform investors and the public of each decision made on these matters.</p> <p>8. In defining the obligations of the investor, it is stipulated that the laws and regulations of Mongolia must be observed, and that investments must be executed in a substantive manner. The draft law provides a specific definition of what constitutes a substantive investment.</p>
3	Functions of Government Agencies Regarding Investment	<p>Article 9. Functions of the Government Article 10. Functions of the Central Administrative Authority Responsible for Investment Article 11. Functions of the Administrative Agency Responsible for Investment Article 12. Functions of Other Government Agencies Regarding Investment Article 13. Functions of Local Administrative and Self-Governing Bodies Regarding Investment Article 14. Powers of</p>	<p>9. It is mandated to ensure the implementation of investment-related laws and regulations. New functions have been established to receive and resolve investment-related complaints and to provide guidance to government agencies.</p> <p>10. The law specifies that the central administrative authority responsible for investment, namely the Ministry of Economy and Development, is solely responsible for attracting investment, promoting the investment environment, and providing services to investors. The administrative agency responsible for investment is tasked with issuing stabilization certificates and coordinating with other authorized government agencies to monitor their implementation.</p> <p>11. The administrative agency responsible for investment is tasked with developing a comprehensive action plan aimed at attracting, retaining, and expanding investments. This includes providing information and guidance to</p>

		<p>Diplomatic Missions in Promoting Investment</p>	<p>investors, supporting the protection of investors' legal rights and interests, generating unified statistical data on the investment environment, and maintaining an investment database.</p> <p>12. Other government agencies are limited to conducting no more than two planned inspections of investor activities per year. They are prohibited from unlawfully halting, suspending, or interfering with investor activities. Unlawful interference may be deemed as expropriation. If a valid court or arbitration decision orders the state to compensate for damages, the responsible party will be required to bear the cost of compensation.</p> <p>13. Local administrative and self-governing bodies are also responsible for carrying out the functions of other government agencies and are accountable under the law. This provision aims to reduce bureaucratic obstacles and additional requirements that unlawfully hinder investor activities.</p> <p>14. Diplomatic missions are tasked with promoting, connecting, and supporting projects and programs that require investment, in cooperation with the central administrative authority responsible for investment. The procedures governing this collaboration will be approved by the government members responsible for foreign affairs and investment.</p>
<p>4</p>	<p>Investment Incentives</p>	<p>Article 15. Investment Incentives Article 16. Non-tax Incentives for Investment Article 17. Tax Stabilization Incentives for Investment Article 18. Conditions and Requirements for Issuing a Stabilization Certificate Article 19. Application for a Stabilization Certificate Article 20. Issuance of a Stabilization Certificate Article 21. Revocation of a Stabilization Certificate Article 22. Investment Agreement Article 23. Application for Entering into an Investment Agreement Article 24. Conclusion of an Investment Agreement Article 25. Monitoring of Implementation of Investment Agreements and Stabilization Certificates</p>	<p>15. Under the Investment Law, it is possible to provide both non-tax incentives and tax rate stabilization incentives.</p> <p>16. Non-tax incentives provide essential support for investors to conduct their activities. These incentives include assistance with land issues, work permits, state registration matters, and residency permits. While the current law allows land use up to 60 years, this has been clarified to specify a minimum duration of 15 to 60 years, in alignment with the Land Law's provisions on land possession rights. Additionally, the authority over land matters has been transferred to the relevant local authorities, as stipulated in the Land Law, rather than requiring decisions solely from the Government.</p> <p>17. It is stipulated that tax rate stabilization incentives will be provided through the issuance of a stabilization certificate or by entering into an investment agreement. This includes stabilizing four types of taxes, retaining the current legal framework. Additionally, provisions in the Investment Law that are not aligned with the General Tax Law's principle of regulating taxes solely through tax legislation have been nullified. Tax support is now referred to as an "incentive," with the incentive period starting from the date the certificate is issued and lasting for the duration of the certificate's validity.</p> <p>18. The process for obtaining a stabilization certificate has been simplified. A stabilization certificate will be granted to investors implementing projects for a</p>

			<p>minimum of five years, with “territories” classified as Ulaanbaatar and other areas. The minimum validity period for a stabilization certificate is set at 10 years. For projects in Ulaanbaatar, the required investment amount is between MNT 20 and 50 billion, while in rural areas, it ranges from MNT 10 to 50 billion. For a 15-year stabilization period, the investment must exceed MNT 50 billion, and for a 20-year stabilization period, the investment must exceed MNT 100 billion.</p> <p>19. It is stipulated that applications for obtaining a stabilization certificate can be submitted electronically. The application must include the legal entity's guarantee, an introduction, a state registration certificate, a business plan, a feasibility study, and (if required by law) a general environmental impact assessment.</p> <p>20. The stabilization certificate will be issued by the central administrative authority responsible for investment.</p> <p>21. The grounds for revoking a stabilization certificate have been specified, retaining the previous legal conditions.</p> <p>22-25. Entities planning to invest MNT 500 billion or more may express a request to enter into an investment agreement. Upon submission of this request, the matter will be presented at a Government meeting, and (with the necessary authorization) the agreement will be jointly signed by the sector minister and the minister responsible for investment. The duration of the agreement will depend on the project's timeline, with a minimum period of 20 years specified in the draft.</p>
5	Procedures for Resolving Investor Complaints	<p>Article 26. Submission and Receipt of Investor Complaints</p> <p>Article 27. Council for the Protection of Investor Rights and Interests and its Operating Procedures</p> <p>Article 28. Review of Investor Complaints</p> <p>Article 29. Final Resolution of Investor Complaints</p>	<p>The investor is granted the right to file a complaint with the Council for the Protection of Investor Rights and Interests; to safeguard their rights and lawful interests and seek redress for damage caused by illegal actions or inactions of government agencies or officials. The Council does not issue binding decisions but provides advisory support and facilitates mediation for resolving issues. Based on its findings, the Council formulates recommendations, presents them to the Government, and enables a final administrative decision to be made by the relevant government authority.</p>
6	Investment Disputes	Article 30. Investment Disputes	<p>1. Investment disputes arising between investors and the state are addressed under the relevant international treaties and conventions to which Mongolia is a party. According to these agreements, including the Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States (ICSID) Convention, an arbitration agreement must be mutually agreed upon in writing.</p> <p>An investor has the right to bring a dispute to arbitration based on any of the following three agreements:</p> <ul style="list-style-type: none"> (i) an investment agreement, (ii) a bilateral international treaty, or (iii) the unilateral arbitration consent granted by the state within the investment law,

			<p>This allows investment disputes to be resolved through international arbitration. When an investor files a claim with arbitration under this consent, it is considered accepted and satisfies the requirement of a written arbitration agreement.</p> <p>This unilateral consent from the state, as outlined in (iii), is a distinctive provision in the draft law, aligning with internationally recognized principles and adopted in the national laws of many countries.</p> <p>2. Disputes falling under the exclusive jurisdiction of the courts, such as those related to taxes and land, are stipulated in Section 32.3 of the draft to be resolved by the courts of Mongolia.</p> <p>3. Commercial disputes between individuals and legal entities are resolved based on mutual agreement. Arbitration agreements are established by mutual consent, allowing the parties to select an arbitration body to resolve their dispute. If an arbitration agreement exists, the parties will resolve the commercial dispute through arbitration; if not, the general provision directs such disputes to be resolved by the courts of Mongolia.</p>
7	Other Provisions	<p>Article 31. Responsibility for Legal Violations Article 32. Transition Arrangements Article 33. Effective Date of the Law</p>	<p>Provisions have been included to address the rights and interests of entities that obtained certificates or entered into agreements under the previous law once the new law takes effect. The law also specifies liability for individuals and legal entities who violate the law, as well as the conditions under which the law will become effective.</p>

INTRODUCTION

Draft revision of the Investment Law of Mongolia

Paragraph 1 of Article 5 of the Constitution of Mongolia states that "Mongolia shall have an economy based on multiple forms of ownership, reflecting global economic development trends and the specific characteristics of the country." Paragraph 4 of the same Article provides that "The State shall regulate the economy in line with national economic security, ensuring the development of all forms of enterprise and the social development of the population."

According to Paragraph 3.2, "Economic Security" in the National Security Concept of Mongolia, adopted under Resolution No. 48 by the State Great Khural in 2010, "Mongolia shall implement a balanced investment policy, promote a multi-pillared and optimal economic structure, build the capacity for economic self-sufficiency, and ensure economic independence and stable operation, while contributing to national income generation."

Objective 4 of Vision-2050, Mongolia's Long-Term Development Policy approved by State Great Khural Resolution No. 52 of 2020, envisions "an economy characterized by sustainable growth benefiting all citizens, a predominant middle class, significant poverty reduction, a solid foundation for economic development policy, self-sufficiency in domestic demand, enhanced export capacity, strengthened investment and savings potential, and a diversified, multi-pillar economic structure." To accomplish this objective, Phase I (2021-2030) outlines that "conditions supportive of foreign investment shall be established," and "an investment-friendly environment shall be fostered, facilitating partnerships between the public and private sectors." Section 4.3.12 of the Vision-2050 action plan for 2021-2030 further mandates that "foreign investment shall be increased, and the regulatory environment improved."

Section 5.2.3 of the *Five-Year Guidelines for the Development of Mongolia (2021-2025)*, approved by State Great Khural Resolution No. 23 of 2020, specifies that "state regulation supporting foreign investment and trade shall be refined, and a unified one-stop policy approach shall be implemented." Section 4.5.3 of the *Government Action Plan of Mongolia for 2020-2024* (approved by Resolution No. 24 of 2020) further mandates that "the rights and interests of foreign investors shall be steadfastly protected, and foreign investment encouraged in priority economic sectors, including infrastructure, mining, energy, food, agriculture, and tourism, as well as in mega projects, with support extended to facilitate concessional loans and grants."

In accordance with Annex 5 of the *New Recovery Policy* (approved by State Great Khural Resolution No. 106 of 2021), which mandates the submission of a draft revision of the Investment Law to the State Great Khural, a legal requirement has arisen to revise the Investment Law.

Since 2015, Mongolia's economic growth has been directly dependent on inflows of foreign direct investment. Approximately 75% of the nation's gross domestic product is generated by the private sector, encompassing production in agriculture, manufacturing, construction, and trade.

As of the first quarter of 2023, Mongolia had received a cumulative total of USD 41.1 billion in foreign investment since 1990, with 73% concentrated in mining, 11% in trade and services, and the remaining 16% distributed across other sectors, underscoring a lack of diversification and a marked concentration in a single sector. Foreign direct investment inflows surged in

2011, driven by mining operations and developments associated with the Oyu Tolgoi project. Over the past decade, Oyu Tolgoi LLC alone has accounted for 42% of Mongolia's total foreign direct investment.

As of the first quarter of 2023, a total of 246,800 business entities were registered nationwide in Mongolia, of which 9,350 were foreign-invested enterprises. From 1990 to 2023, 14,836 foreign-invested businesses were registered, with 5,486 subsequently dissolved. Among these dissolved entities, 33% ceased operations between 2010 and 2022. Over the past three years, foreign-invested enterprises contributed an average of 23% (MNT 2.63 trillion) of the total taxes paid by businesses. However, in 2022, this contribution declined to 16% (MNT 2.4 trillion).

Given the above, it is essential for Mongolia to enhance its financial climate by attracting investment through the provision of comprehensive market research and information to investors, streamlining the processes for registration and permit acquisition for new investments, ensuring stability across all investment phases, facilitating efficient business operations, and establishing conditions that protect the legal rights and interests of investors. This includes implementing a system for addressing grievances and resolving disputes.

Given that investment activities span all sectors and economic operations, it is necessary to support investment by aligning policies and legislation across national, sectoral, inter-sectoral, and local levels, and by strengthening interagency cooperation.

Since the adoption of the Investment Law by the State Great Khural in 2013, a total of 11 amendments have been introduced, most of which were supplementary changes tied to other laws. This has highlighted the need to clarify certain regulatory relationships within the Investment Law and to enhance coherence among related legislation.

Based on the above-stated requirements, and with the objective of promoting economic growth through increased foreign direct investment and addressing challenges within the investment environment, a draft revision of the Investment Law has been prepared in accordance with Article 25 of the Law on Legislation.

In accordance with the Law on Legislation, the draft Investment Law was made available online in both Mongolian and English for a period of 65 days (from April 14 to June 19, 2023) to solicit public feedback. Two open discussions on the draft were also conducted, engaging approximately 250 representatives from over 120 organizations, including international organizations, development partners, embassies in Mongolia, professional associations, business councils, chambers of commerce, government agencies, and both domestic and foreign entities. Additionally, more than ten series of meetings were held with investors and representatives of professional associations to ensure broad public participation.

A total of 695 comments were received on the draft law from international organizations, development partners, embassies in Mongolia, professional associations, business councils, chambers of commerce, government agencies, domestic and foreign businesses, and citizens. Of these, 60% were incorporated into the draft, 20% were not included, and the remaining 20% comprised general remarks. Feedback was provided to the commenting organizations, detailing how their input was reflected in the draft law.

The draft law has been developed with an emphasis on ensuring stability in the investment environment, promoting investment, safeguarding the rights and lawful interests of investors,

enhancing investment guarantees, and improving and streamlining government services provided to investors. To achieve these objectives, the following ten key principles have been addressed:

- Certain prohibitive and restrictive regulations on investment activities have been removed.
- Investor guarantees have been enhanced in line with international best practices.
- A Council for the Protection of Investor Rights, including a grievance resolution mechanism, has been established, with detailed provisions on resolving complaints.
- The right to resolve investment disputes between investors and the government through international arbitration has been secured.
- The responsibility to protect and promote investment has been defined as a core function across all government agencies.
- Amendments have been introduced to regulate tax incentives through the tax law.
- Measures to eliminate duplication in scheduled government inspections have been incorporated.
- Criteria for issuing Stabilization Certificates have been simplified, with provisions for electronic issuance.

With the approval of the revised draft of the Investment Law, the following economic, social, and legal outcomes are anticipated:

1. A favorable investment climate will be established, creating conditions for: attracting foreign direct investment, encouraging reinvestment, increasing capital inflows, and ensuring sustainable economic growth.
2. Economic diversification will be supported, along with increased production and exports of high-value-added products. Expansion in foreign trade and the introduction of advanced technology and know-how will improve the quality of goods, products, and services, boost innovation, and enhance Mongolia's competitive advantage.
3. Stable employment opportunities will be created, facilitating the acquisition of new knowledge and skills, increasing workforce participation and employment, and leading to higher average wages and household incomes.
4. Investment-driven infrastructure development will advance, reducing transportation and logistics costs, improving supply chain efficiency, and enhancing the potential to attract new investment.
5. Increased investment will expand the tax base and boost budget revenues, accelerating national and regional development and supporting the improvement of quality and accessibility of public services.

The draft law consists of seven main chapters and 33 articles; accompanied by draft resolutions of the State Great Khural, including the Resolution on Annulment of Previous Laws, the Resolution on Ensuring the Implementation of the Law, and draft amendments to 18 related laws.

At the 27th session of the Government on June 21, 2023, it was resolved to present the draft revised version of the Investment Law, along with related legislative proposals, to the State Great Khural.

GOVERNMENT OF MONGOLIA

ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтална” гэж тусгасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно”, уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, мөн “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, мөн ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.12-т “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.3-т “Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 5 дугаар хавсралтад Хөрөнгө оруулалтын тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж тус тус заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн хэрэгцээ шаардлага бий болсон.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалаас шууд хамаарч байна. Түүнчлэн дотоодын нийт бүтээгдэхүүний 75 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг ба хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, худалдаа зэрэг салбарын үйлдвэрлэлийг хувийн хэвшил дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсад 1990-2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 41.1 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 73 хувь нь уул уурхайн олборлолт 11 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Оюутолгой төслийн уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оноос эрс нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг “Оюутолгой” ХХК дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 246.8 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 9,350 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14,836 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 5486 аж ахуйн нэгж татан буугдсан байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 33 хувь нь 2010-2022 онд татан буугдсан байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар аж ахуйн нэгжийн төлсөн нийт татварын 23 хувийг буюу 2.63 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүрдүүлсэн бол 2022 онд 16 хувь буюу 2.4 их наяд болж буурсан байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Улсын Их Хурлаас 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталснаас хойш нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дийлэнх өөрчлөлт нь бусад хуулийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон тул хуулиар зохицуулж буй зарим төрлийн харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд дээр дурдсан нөхцөл шаардлагад үндэслэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл буюу 65 хоногийн хугацаанд хуулийн төслийг монгол, англи хэлээр цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авсан. Мөн олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын 120 гаруй байгууллагын 250 орчим төлөөллийг оролцуулан хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 2 удаа, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөлүүдтэй 10 гаруй цуврал уулзалтуудыг зохион байгуулан олон нийтийн оролцоог хангаж ажиллалаа.

Хуулийн төсөлд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг хүлээн авлаа. Нийт ирүүлсэн 695 саналын 60 хувийг хуулийн төсөлд тусгаж, 20 хувийг тусгаагүй, 20 хувь нь сэтгэгдэл байсан бөгөөд санал ирүүлсэн байгууллагуудад хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар хариу мэдэгдэж ажилласан.

Хуулийн төслийг хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг сайжруулах, хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, төрийн үйлчилгээг сайжруулж, хялбаршуулахыг зорьж дараах 10 зарчмын асуудлуудыг шинээр тусган боловсруулаад байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан зарим зохицуулалтуудыг арилгасан.
- Хөрөнгө оруулагчдад үзүүлэх баталгааг олон улсын сайн туршлагад нийцүүлэн сайжруулсан.
- Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл буюу гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж, гомдлыг шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тусгасан.
- Хөрөнгө оруулагч, төр хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитрын журмаар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан.
- Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих үүргийг төрийн бүх байгууллагуудын чиг үүрэг болгон тодорхойлж тусгасан.

- Татварын урамшууллын асуудлыг татварын хуулиар зохицуулах өөрчлөлт оруулсан.
- Төрөөс хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын давхардлыг арилгах зохицуулалтыг оруулсан.
- Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг хялбаршуулж, цахимаар олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах үр дүн гарна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

2. Эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, дэвшилтэд техник технологи, ноу-хау нэвтэрснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, инновацыг дэмжих замаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дээшилнэ.

3. Тогтвортой ажлын байр бий болж, шинэ мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, дундаж цалингийн хэмжээ болон өрхийн орлого нэмэгдэнэ.

4. Хөрөнгө оруулалтад тулгуурлан дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалт нэмэгдэж, тээвэр, логистикийн зардал буурах, ханган нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг нэмэгдэх, улмаар шинээр хөрөнгө оруулалт татах боломжийг бий болгоно.

5. Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэн улс болон орон нутгийн хөгжлийг хурдасгаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Хуулийн төсөл нь үндсэн 7 бүлэг, 33 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төслийг дагалдаж Хууль хүчингүй болсонд тооцох тухай, “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад 18 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулсан.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР